

## ХЭҮК-ООС ИРГЭДИЙН ӨМГӨӨЛҮҮЛЭХ, ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙН ТАЛААР ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ХЭҮК-оос тусгай удирдамж гаргаж, 19 аймаг нийслэл хотыг хамруулан иргэдийн өмгөөлөгчөө сонгох эрх зүйн туслалцаа авах эрхийн төлөв байдалд судалгаа хийж үзэв. Судалгаанд ХЭҮК-ын ажилтнууд, түүнчлэн хөдөө орон нутаг дахь итгэмжлэгдсэн төлөөлөгч нар оролцож өмгөөлөгчид, урьдчилан хорих байруудад хоригдож буй хүмүүс, гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж буй хүмүүс болон жирийн иргэдээс санал асуулгын хуудсаар судалгаа авах, өмгөөллийн байгууллага, төрийн байгууллагын ажилтнуудаас лавлагаа авах, бичиг баримт үзэж танилцах аргуудыг хэрэглэн дүнг гаргасан болно.

### Нэг. Өмгөөлөгчдийн хүрэлцээ, сонгон шалгаруулалтын талаар

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16-р зүйлийн 14 дэх хэсэгт “ Монгол улсын иргэн өөрөө өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй ” гэж тодорхойлжээ.

Түүнчлэн одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд “Сэжигтэн яллагдагч, шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, эрх зүйн туслалцаа авах, өмгөөлөгчөө өөрөө сонгон авах, гэмт хэрэгт сэрдэгдэж албадан саатуулагдсан үеэсээ өмгөөлөгч авах, өмгөөлөгчөө өөрөө сонгох эрхтэй, өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах эрхтэй ” гэж тус тус заасан.

Гэвч ЭБШ Хуулийн 47-р зүйлд Эрүүгийн хэрэгт улсын яллагч оролцож байгаа тохиолдолд өмгөөлөгч заавал оролцохоор зааснаас шалтгаалан аливаа эрүүгийн шүүх хуралд прокурор бүгдэд нь оролцдог тул хүссэн хүсээгүй өмгөөлөгч заавал авах болдог байна. Иймээс өөрөө өөрийгөө өмгөөлөх эрх нь хэрэгжихгүйд хүрч хэлбэрийн төдий өмгөөлөгч заавал авахад хүрдэг байна.

Монгол улсад сонгон шалгаруулалтанд орж тэнцэн, зөвшөөрөл авсан 512 өмгөөлөгч байгаагийн 55,8 хувь нь буюу 287 өмгөөлөгч Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг байна. Дээрх өмгөөлөгчид нь 21 зөвлөл 42 товчоонд харъяалагдаж ажилладаг байна. Судалгаанаас үзвэл хөдөө аймгуудад мэргэжлийн өмгөөлөгчдийн хүрэлцээ хангалтгүй, ихэнх аймгуудад 2-5 өмгөөлөгч ажилладаг байна.

Хөдөө орон нутагт мэргэжлийн өмгөөлөгч ховор байдгаас өмгөөлөгчөө сонгох сонголт хязгаарлагдмал, хүссэн хүсээгүй хоёр, гуравхан байгаа өмгөөлөгчийн аль нэгийг авахад хүрдэг, зарим тохиолдолд өмгөөлөгч олдохгүй хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд саад бэрхшээл учруулдаг зэрэг хүндрэл бэрхшээл байгааг судалгааны дүн харуулж байна.

Мэргэжлийн өмгөөлөгчийн хүрэлцээ хангалттай биш байхад сүүлийн 4 жилийн хугацаанд өмгөөлөгчийн сонгон шалгаруулалт нэг ч удаа хийгдээгүй байна.

Түүнчлэн өмгөөлөгчдийн дунд мэргэжлийн болон давтан сургалт хийгддэггүйгээс тэд төрийн байгууллагын ( шүүгч, прокурор, мөрдөн байцаагч ) эрх мэдэл бүхий ажилтнуудтай хүний эрхийн талаар мэтгэлцээнд тэр бүр бэлэн биш байдаг гэж зарим хүмүүс үздэг байна.

Иймээс өмгөөлөгчдийг давтан сургах, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх асуудлыг төрөөс санхүүжүүлэх, хариуцах шаардлагатай байна. Өмгөөллийн тухай

хуулийн 3-р зүйлд өмгөөлөгчийн үйл ажиллагаа төрийн ивээлд байна гэсэн боловч энэ чиглэлээр төрөөс өнөөг хүртэл тодорхой ажил хийгдсэнгүй.

Өмгөөлөгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх талаар төсөл хөтөлбөрүүд огт хэрэгждэггүй, гаднын байгууллага, сангаас тусламж дэмжлэг авах нь ховор байдаг байна.

### **Хоёр. Өмгөөлөгчдийн хөлсний хэмжээ, үнэлгээний талаар**

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Өмгөөллийн тухай хуулийн 16-р зүйлд өмгөөлөгчийн хөлсний жишгийг хууль зүйн болон, хүн амын бодлого хөдөлмөрийн сайд хамтран тогтооно, талууд тохиролцвол жишгийг ихэсгэж багасгаж болно гэж заасан. Үүнээс үзвэл өмгөөлөгчийн хөлсийг ямарч тохиолдолд талууд харилцан тохиролцож болохоор байна.

Хууль зүйн сайд, Хүн амын бодлого хөдөлмөрийн сайдын 1995 оны 44/63-р тушаалаар баталсан хууль зүйн туслалцаа үзүүлэхэд төлөх хөлсний жишгийг баталж, эрүү, иргэний хэрэг, анхан болон давах хяналтын шат зэргээр нь ангилж нарийвчилсан жишиг тогтоожээ.

Тэгээд ч хөдөлмөрийн хөлсний үнэлгээ, иргэдийн амьдралын баталгаажих доод түвшинд эрс өөрчлөлт гарсан байхад энэ жишиг өдий хүртэл үйлчилж ирсэн ба энэ жишгийг амьдрал дээр тэр бүр баримталдаггүй, хөлсний хэмжээг өмгөөлөгч болон өмгөөлүүлэгч харилцан тохиролцож тогтоож ирсэн нь өмгөөлөгчид үйлчлүүлэгчдээс авсан санал асуулгаас тодорхой байна. Шинээр батлагдсан Өмгөөллийн тухай хуулинд хөлсийг зөвхөн талууд харилцан тохиролцож шийдвэрлэх, ямар нэгэн жишиг байхгүйгээр тусгагдсан нь эрх зүйн туслалцаа үзүүлэх иргэний эрх зүйн гэрээний зарчимд бүрэн нийцжээ.

Өмгөөлөгчид өмгөөлүүлэгчээс шаардаж буй хөлсний хэмжээ ямар байгаа талаар үйлчлүүлэгчид (аймаг нийслэлд цагдан хоригдож байгаа хүмүүс), иргэдээс өмгөөлөгчийн санал болгосон хөлс өндөр байдаг, боломжийн байдаг, бага байдаг гэсэн 3 асуудлаар санал асуулга авч судалгаа хийв. Цагдан хоригдож буй 783 хүнээс дээрх гурван асуудлаар асуулга авахад 31,0 хувь нь өндөр байдаг, 412- нь буюу 62,4 хувь нь боломжийн байдаг, 6,6 хувь нь бага байдаг гэж хариулжээ. Энгийн иргэдээс мөн дээрх асуудлаар санал асуулга явуулахад 18,3 хувь нь өндөр байдаг, 33,4 хувь нь боломжийн, 45,5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Харин өмгөөлөгчид болон иргэдтэй уулзаж ярилцлага хийх явцад нэр хүндтэй өмгөөлөгчдийн хөлс харьцангуй өндөр байдаг болох нь харагдаж байв.

Өмгөөлөгч нар нь үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө чинээний байдал, төлбөрийн чадвар, хэргийн байдалд тохируулан өмгөөллийн хөлсөө тохиролцох, мөн өмгөөллийн эцсийн үр дүнтэйгээ харилцан хамааралтай байх зарчимд нийцүүлэн авч байх шаардлагатайг дээрх судалгаа харуулж байна.

### **Гурав. Төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн хөлсний талаар**

Төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн зардалд зориулан улсын төсөвт тусгасан мөнгийг ХЗДХ-ийн яаманд олгох талаар албан ёсны шийд гараагүй байхад төсвийг ХЗДХ-ийн яам авч зориулалтын бусаар зарцуулсаар 2 жил болж, өмгөөлүүлэгч болон өмгөөлөгчийн эрх ашгийг хохироосон байна. Судалгаанаас үзвэл энэ зардалд мөнгө төсөвлөдөг боловч зарцуулагддаггүй жил бүр хэмнэлттэй гардаг байна. Гэтэл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд төлбөрийн чадваргүй

иргэдэд өмгөөлөгч томилж оролцуулаад хөлс нь төлөгддөггүй тохиолдол олон гардаг байна. Тухайлбал: 2001-2002 онд Нийслэлийн хэмжээнд 150 орчим хүнд өмгөөлөгч томилж оролцуулсан боловч нэг ч өмгөөлөгч хөлсөө аваагүй байна.

Өмгөөллийн тухай шинэ хуулиар төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн зардлын санхүүжилтийг өмгөөлөгчдийн холбоонд олгох, санхүүжүүлэх тайлан тооцоо гаргах журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн Газрын гишүүн батлахаар заажээ.

Иймээс төлбөрийн чадваргүй иргэнийг тодорхойлох, өмгөөллийг хөлсний хэмжээг жирийн иргэдийн өмгөөллийн хөлсний жишигт ойртуулах, төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөгчийг нь нэр зааж шууд томилдог бус өөрсдийнх нь санал хүсэлтийг харгалздаг болгох журмыг болвсронгуй болгох, өмнөх 2 жилд зарцуулагдаагүй мөнгийг Өмгөөлөгчдийн холбоонд олгох шаардлагатай.

Төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг Хууль зүйн сайд, Сангийн сайд, ХАБХ-ийн сайдын 1995 оны 5-р сарын 4-ний 73/76/62 тоот тушаалаар баталсан журмаар зохицуулжээ. Энэхүү журамд зааснаар хэрэгт холбогдогчийн сарын орлого нь Засгийн Газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүй, үүнээс шалтгаалан байнгын хязгаарлагдмал хэрэглээтэй амьдардаг иргэдийг төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгч гэж үздэг байна.

Төлбөрийн чадваргүй гэдгийг нь Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга тусгай журамд <sup>1</sup> зааснаар тодорхойлж тусгай маягтаар шүүх болон мөрдөн байцаагчид хүргүүлж, шүүгч, мөрдөн байцаагч мөн анкетыг бөглөж шүүхийн тамгын газар (нягтлан бодогчид) -т хүргүүлж, тэндээс батлагдсан жишгийн дагуу хөлсийг бэлнээр олгодог байна.

Хөлсний жишгийг хөнгөн хэрэгт 3500, хүндэвтэр хэрэгт 6000, хүнд хэрэгт 8000, онц хүнд гэмт хэрэгт 12000 төгрөгөөр тогтоожээ. Энэ нь ердийн өмгөөллийн хөлснөөс 4 дахин бага байна. Төлбөрийн чадваргүй гэж тодорхойлогдсон иргэнд өмгөөлөгч томилж өгөхийг шүүгч болон мөрдөн байцаагч аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлд санал болгож, зөвлөлийн дарга өмгөөлөгчийг томилдог байна.

Түүнчлэн шүүхийн тамгын газарт ирсэн материал нь бүрдэл дутуу байдгаас мөнгө олгогдохгүй тохиолдол багагүй гардаг байна.

Гурван яамны хамтарсан тушаалаар батлагдсан журамд төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн хөлсийг шүүхийн байгууллагын төсөвт нэг зүйл анги болгон баталж, шүүхийн ерөнхий зөвлөл аймаг, нийслэлийн шүүхэд хуваарилахаар заажээ.

Энэ журмын дагуу 2001 он хүртэл энэ зардал шүүхийн төсөвт тусгагдан зарцуулагдаж байсан боловч 2001 оноос эхлэн Хууль Зүйн Яамны төсөвт тусгагдаж эхэлсэн байна. Энэ зардлыг Хууль Зүй Дотоод хэргийн Яамны төсөвт шилжүүлэх талаар албан ёсны шийдвэр гаргасан эсэх нь тодорхойгүй байна. Төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн зардал ( ) аймагт 1998 оноос хойш огт хуваарилагдаагүй байна.

Сүүлийн 5 жилээр энэ зардлын төсөвлөлт гүйцэтгэлийг улсын хэмжээгээр харуулбал:

<sup>1</sup>хүн амын бодлого хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1993 оны 156/199 тоот тушаалд батлагдсан "Амьдрал ядуу бага орлоготой өрх, иргэдэд туслах сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах" журам

	Батлагдсан төсөв (мян.төг)	Зарцуулсан мөнгө (мян.төг)	Хэмнэлт	Ямар байгууллагын төсөвт тусгагдсан
1998	2000,0	1995,0	+5,0	Шүүх
1999	3000,0	1112,5	+881,5	Шүүх
2000	6500,0	2100,0	+4400,0	Шүүх
2001	9000,0	0	9000,0	ХЗДХЯ
2002	9000,0	0	9000,0	ХЗДХЯ

Төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн хөлсийг авахад бүрдүүлэх бичиг баримт шат дамжлага олон, хэмжээ бага байдаг учир энэ хөлсийг өмгөөлөгчид авахыг нэг их сонирхдоггүй орхидог байна.

### Дөрөв. Өмгөөлөгчдөөс авсан санал асуулгын талаар

Нийслэл болон аймгуудад ажиллаж буй 164 өмгөөлөгчөөс 34 асуултаар санал авч дүнг нэгтгэж үзэв. Санал асуултанд хамрагдсан 164 өмгөөлөгчийн 39,6 хувь нь 1-5 жил, 25,0 хувь нь 5-10 жил, 23,7 хувь нь 10-20 жил, 12,1 хувь нь 20-иос дээш жил ажилласан, 39,6 хувь нь шүүхэд, 18,2 хувь нь прокурорт 26,8 хувь нь Засаг Захиргааны байгууллагад ажиллаж байсан байна.

Монголын нийт өмгөөлөгчдийн нас, хүйс, ажилласан жил, урьд өмнө эрхэлж байсан ажил мэргэжлийн талаар нарийвчилсан нэгтгэсэн судалгаа байдаггүй байна. Дээрх судалгааны явцаас үзвэл өмгөөлөгчдийн дийлэнх нь цөөн жил ажилласан залуу хуульчид гэдэг нь харагдаж байна.

Цагдан хоригдож байгаа сэжигтэн болон яллагдагчтай ганцаарчлан уулзахад хүндрэл гардаг уу гэж асуухад судалгаанд оролцсон өмгөөлөгчдийн 42,8 хувьд хүндрэл гардаг гэж, 51,2 хувь нь хүндрэл бэрхшээл гардаггүй гэж хариулсан байна. Энэ дүнгээс харвал өмгөөлөгч сэжигтэн яллагдагчтай ганцаарчлан, чөлөөтэй уулзах эрх нь багагүй хязгаарлагддаг, тэнд ямар нэгэн бэрхшээл саад учирдаг гэж дүгнэж болохоор байна.

Хууль зүйн сайдын 1998 оны 83-р тушаалаар цагдан хоригдсон болон албадан саатуулагдсан этгээдтэй уулзах, эрх зүйн туслалцаа үзүүлэх журмыг баталсан байна. Энэ журмаар уулзалтын тусгай өрөөтэй байх, ажлын цагт багтаан хязгаарлалтгүй уулзах, уулзахдаа өмгөөлөгчдийн зөвлөлөөс томилолт, зөвшөөрөл авахаар заажээ. Гэвч өмгөөлөгчид зөвлөлөөс томилолт авч хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчаар нь цохуулдаг, зарим тохиолдолд мөрдөн байцаагч уулзахыг зөвшөөрдөггүй гэсэн гомдол гарсан байна.

Судалгааны явцад зарим аймаг уулзалтын тусгай өрөө байдаггүй, хэрэг бүртгэлийн шатанд бараг уулзуулдаггүй гэсэн гомдол гарсан байна. Тухайлбал Ховд аймагт уулзалтын байргүй, ганцаарчлан уулзахыг цагдаагийн ажилтнууд зөвшөөрдөггүй гэсэн гомдол гарсан байна.



Иймээс дээрх журмыг хянан үзэж, хэрэгт холбогдогчтой уулзахад зөвшөөрөл олгодог бус уулзах эрхийг нь чөлөөтэй болгосон журмыг өөрчлөн тогтоох шаардлагатай байна.

Судалгаанд хамрагдсан өмгөөлөгчдийн 80,4 хувь нь хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанд гаргасан гомдлоо бичгээр гаргадаг, 28,0 хувь нь аливаа хүсэлт гаргахад хүндрэл бэрхшээл гардаг гэж 58,5 хувь нь бидний тавьсан хүсэлтэд шүүхээс дунд зэрэг ханддаг гэж, 73,1 хувь нь бидний тавьсан хүсэлтийн ихэнх нь буюу зарим нь биелдэггүй гэж тус тус хариулсан байна. Энэ судалгаанаас үзвэл шүүхээс болон мөрдөн байцаах газраас өмгөөлөгчид хандах хандлага сайнгүй, тэдний тавьсан санал хүсэлтийн ихэнх нь хэрэгждэггүй гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Иймд хуульчдын зүгээс өмгөөлөгчид хандах хандлагыг өөрчлөх, нийгмийн сэтгэл зүйд, өмгөөлөгчдийн нэр хүндийг сайжруулах, ялангуяа шүүгчдээс прокурор болон өмгөөлөгчид тэгш хандах, тэднийг нэг хэргийн мэтгэлзэх 2 тал хэмээн тавьсан санал хүсэлтийг нь адилхан үнэлж дүгнэх сэтгэхүйг тогтоох шаардлагатай байна.

### **Тав. Иргэд ба цагдан хоригдогсдоос авсан санал асуулгын талаар**

Иргэн өөрөө өөрийгөө өмгөөлөх, эрх зүйн туслалцаа авах эрхээ хэр мэдэх, өмгөөлөгч авах нь ашигтай эсэх, өөрөө өөрийгөө өмгөөлж чадах эсэх, өмгөөлөгчид итгэх итгэлийн талаарх санал асуулгад эрэгтэй 694, эмэгтэй 622 бүгд 1316 хүн хамрагдсан байна.

Тэдний 70,7 хувь нь өөрөө өөрийгөө өмгөөлөх, эрх зүйн туслалцаа авах эрхийнхээ талаар тааруухан мэдлэгтэй гэж, 83,4 хувь нь ямар нэгэн юм болсон тохиолдолд өөрөө өөрийгөө өмгөөлж чадах эсэх талаар эргэлзэж байна гэж, 70,2 хувь нь намайг баривчлах саатуулах гэвэл өмгөөлөгчид хандана гэж, 75,1 хувь нь өмгөөлөгч авах нь ашигтай гэж хариулсан байна. Энэ үзүүлэлт нь иргэдэд өнөөдөр өөрөө өөрийгөө өмгөөлөх чадвар, эрх зүйн боловсрол бүрдээгүй, өмгөөлөгчийн хэрэгцээ бага байгааг харуулж байна.

Харин өмгөөлөгчийн чадвар, ажлын арга барилын талаар асуулгад оролцогсдын 53,4 хувь нь өмгөөлөгчдийн ур чадвар, үйлчилгээний чанар тааруухан гэж хариулсан байна.

Судалгааны явцад цагдан хорих байруудад хоригдож байсан 783 хүнээс судалгаа авахад 45,3 хувь нь өмгөөлөгч авах боломж олдоггүй гэж хариулж, 42,4 хувь нь өмгөөлөгч аваагүй байсан байна. Үүнээс харахад хэрэгт сэжиглэгдэн цагдан хоригдож байгаа этгээдүүдэд өмгөөлөгч авах боломж муу ихэнх нь өмгөөлөгч авч чаддаггүй байна. Түүнчлэн хэрэгт холбогдогчид хэдий үеэс эхлэн өмгөөлөгч авдгийг судалж үзэхэд 32,6 хувь нь яллагдагчаар татагдсанаасаа хойш, 22,3 хувь нь шүүхэд шилжих шатанд, 31,0 хувь нь эрүү үүсгэсэн буюу албадан саатуулагдсанаасаа хойш, 13,9 хувь нь прокурорт хянагдах шатанд өмгөөлөгч авсан гэж тус тус хариулжээ.

Энэ асуудлыг өмгөөлөгчдийн дунд санал асуулга явуулж судалж үзэхэд судалгаанд хамрагдсан өмгөөлөгчдийн 34,7 хувь нь яллагдагчаар татагдсан үеэс, 30,4 хувь нь шүүхийн шатанд, 23,7 хувь нь сэжигтнээр татагдсан үеэсээ өмгөөлөгч авахыг хүсдэг гэж хариулсан байна. Энэ судалгаанаас харвал хэрэгт холбогдогсод өмгөөлөгчөө сонгох эрх зүйн туслалцаа авах эрхээ нилээд хожуугаас эдэлж эхэлдэг төдийгүй, тэдний бараг гуравны нэг нь шүүхэд очих шатанд өмгөөлөгч авдаг гэж дүгнэж болохоор байна.

Түүнчлэн хэрэгт холбогдогч байцаагдахдаа өмгөөлөгч авах хүсэлт гаргаж байсан эсэх, энэ хүсэлтийг нь хангадаг эсэх талаар судалгаа явуулж үзэв. Судалгаанд

хамрагдсан цагдан хоригдож байсан 783 хүний 19,1 хувь нь байцаалтанд өмгөөлөгч байнга оролцдог гэж, 24,5 хувь нь огт оролцдоггүй гэж 33,1 хувь нь өмгөөлөгч оролцуулах талаар хүсэлтийг хангадаггүй гэж тус тус хариулсан байна. Энэ дүнгээс үзвэл сэжигтэн яллагдагчийг байцаахад өмгөөлөгчийг оролцуулах үзүүлэлт хангалтгүй, өмгөөлөгч оролцуулах хүсэлтийг хлээн авдаггүй дутагдал багагүй байгаа нь харагдаж байна.

### **Зургаа. Судалгаанаас гарсан дүгнэлт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал**

1. Өмгөөлөгчдийн хэрэгцээ шаардлага их хөдөө орон нутагт өмгөөлөгчдийн хүрэлцээ муу байгаад дүгнэлт хийж сонгон шалгаруулалт явуулж өмгөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх
2. Өмгөөлөгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, давтан сургах талаар төрөөс туслалцаа үзүүлэх, Монголын өмгөөлөгчдийн холбооны санал санаачлагыг дэмжих энэ талаарх хамтын ажиллагааг бэхжүүлэх
3. Төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн хөлсний үнэлгээг өөрчилж, жирийн өмгөөллийн түвшинтэй харьцуулж тогтоох, төлөвлөлт зарцуулалтыг боловсронгуй болгох, өнгөрсөн 2 жилд олгогдоогүй төсвийг нөхөн олгуулах
4. Албадан саатуулагдсан болон цагдан хоригдсон этгээдтэй өмгөөлөгчид чөлөөтэй уулзах нөхцөл бололцоог бүрдүүлэх, энэ талаар мөрдөж буй журмыг хянан үзэж өөрчлөх, уулзалтын өрөөгүй газруудад уулзалтын өрөө бий болгох
5. Өмгөөлөгчийн хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатнаас эхлэн оролцуулах арга хэмжээг авхуулахаар холбогдох газруудад нь санал тавих нь зүйтэй гэж үзэв.

Судалгааны тайлан бичсэн:

ХЭҮК-ЫН ГИШҮҮН



Ж. ДАШДОРЖ

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН